

**Монгол Улсын Засгийн газраас баталсан
“Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд
оруулан хадгалах хөтөлбөр”-ийн тайлан**

2009 оны 12-р сарын байдлаар

| № | Хөтөлбөрийн агуулга | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 1 | Хөтөлбөрийн баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо | 2005.12.07 өдрийн № 244-р тогтоол |
| 2 | Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа | 2006-2008 |
| 3 | Хөтөлбөрийн зорилго | Үндэсний соёлын өвийн талаархи бүрэн мэдээллийг бүрдүүлэх, соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоог сайжруулж, соёлын өвийн мэдээллийг тоон технологи, электрон хэлбэрт оруулан нэгдсэн сүлжээ бий болгон, мэдээллийг шуурхай харилцан солилцох, найдвартай хадгалах нөхцлийг бүрдүүлэх зорилготой. |
| 4 | <p>Хөтөлбөр хэрэгжүүлэх үе шат, зорилтууд (2006-2008)</p> <p>I үе. (2006 оны VI сараас 2007 оны II сар) 1. Соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулах програм хангамжтай болох</p> <p>II үе. (2007 оны I-IX сар) 2. Байгууллагуудыг гэрэл зургийн тоног төхөөрөмж, компьютер, дагалдах хэрэгслээр хангах, 3. Програм хангамж, техник хэрэгсэл дээр ажиллах боловсон хүчинг бэлтгэх</p> | <ul style="list-style-type: none"> ▪ Музейн үзмэрийг бүртгэх “RCH буюу Registration of Cultural Heritage” 1.0 програмыг зохион, хөтөлбөрт хамрагдсан 36 байгууллагад тараан суурилуулсан. Энэ програмын дагуу хийсэн үзмэрийн бүртгэлийг музейнүүдээс интернет сүлжээгээр УНБМСанд хүлээн авч, архивлан хадгалж байна. ▪ “Мэдээлэл боловсруулах CCH” програм нь RCH програм дээр үндэслэгдэж, 36 байгууллагаас цуглагдан ирж байгаа бүртгэлийг УНБМСанд нэгтгэн сан үүсгэх, цугларсан мэдээлэлд боловсруулалт хийх зориулалттай зохиогдсон. ▪ “RICH буюу Registration of Immovable Cultural Heritage” програм нь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэхэд зориулсан програмыг зохион бэлэн болгосон бөгөөд одоо туршилтын журмаар ашиглагдаж байна. Энэ 3 төрлийн програм хангамжийг электрон мэдээллийн чиглэлээр ажилладаг “Андромедиа” ХХК зохион бүтээсэн. ▪ 2007 оны 4-р сарын 18-ны өдөр БСШУЯам, “М СИ ЭС” ХХК-ын хооронд ТТ2007-2 тоот гэрээгээр 35 байгууллагад нийлүүлэх компьютер, принтер, тог баригчийг нийлүүлсэн. ▪ 2007 оны 6-р сарын 15-ны өдөр БСШУЯам, “Номин электроникс” ХХК-ний хооронд байгуулсан гэрээгээр 35 байгууллагад нийлүүлэх гэрэл зургийн аппарат, дагалдах хэрэгслийг 8-р сарын 04-ний дотор бүрэн нийлүүлсэн. ▪ Соёлын өвийн төвийн УНБМСанд архивын сейф, зарим тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлыг “New boss”, “Tsum trade”, “ПДМС” ХХК-тай хуулийн дагуу сонгон шалгаруулалт хийж, гэрээ байгуулан |

| | | |
|---|--|---|
| | | <p>гүйцэтгэсэн.</p> <ul style="list-style-type: none"> 2007 оны 6-р сарын 11-15-ны хооронд бүртгэл хийх арга зүй, компьютерийн програм хангамж дээр ажиллах мэргэжилтэнг бэлтгэх сургалт семинар зохион байгуулсан. Сургалтанд 34 байгууллагаас нийт 67 хүн хамрагдсан. 35 байгууллагыг 4 бүс болгон, нийлүүлэх тоног төхөөрөмжийг 2007 оны 8-р сард зүүн болон говийн бүсийн аймгуудад, 9-р сард баруун бүсийн аймгууд болон Улаанбаатар хотын улсын музей, бусад байгууллагад тоног төхөөрөмжийг суурилуулан хүлээлгэн өгсөн. Энэ үеэр 34 байгууллагатай “Тоног төхөөрөмж ашиглах тухай гэрээ”, “Бүртгэл ирүүлэх тухай” гэсэн 2 төрлийн гэрээг хийж, гарын үсэг зурж баталгаажуулсан. |
| | <p>III үе. (2007 оны X сараас 2008 оны XII сар)</p> <p>4. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд соёлын өвийг бүрэн хамруулах</p> <p>5. Үндэсний соёлын өвийн мэдээллийг улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд төвлөрүүлэн, архивлан хадгалах</p> | <ul style="list-style-type: none"> Соёлын өвийг электрон хэлбэрээр хүлээж авах, интернетийн зардлыг 35 байгууллагад шилжүүлэн, www.monheritage.mn веб сайт бий болгон онлайн сүлжээ үүсгэн, соёлын өвийг бүртгэх, дамжуулах интернет сүлжээ бий болгосон. 2007-2008 онд музейн сан хөмрөгийн улсын тооллого явгдсантай холбогдуулан бүртгэл ирүүлэх ажил хойшлогдсон бөгөөд 2009 оны эхлэн идэвхжиж байна. УНБМСангаас музейн сан хөмрөгийн улсын тооллогоор тоологдсон үзмэрийн тоонд тулгуурлан музейгээс улирал, жилд ирүүлэх үзмэрийн бүртгэлийн график гарган хүлээн авч, цахим хэлбэрээр УНБМСанд архивлан хадгалах ажил хийгдэж байна. |
| 5 | Хөтөлбөрийн хэрэгжилтээс гарах үр дүн | <ol style="list-style-type: none"> Соёлын өвийн талаархи мэдээлэл бүрэн тоон системд орно. Соёлын өвийн мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болж, орчин үеийн мэдээллийн түвшинд хүрсэн байна. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоо сайжирна. Электрон шуудангаар бүртгэл-мэдээллээ авдаг тогтолцоонд орно. Соёлын өвийн мэдээллийг шуурхай харилцан солилцох нөхцөл бүрдэнэ. Соёлын өвийн бүрэн мэдээлэлтэй болж ашиглах, сурталчлах таатай орчин бүрдэнэ. Соёлын өвийн бүртгэл-мэдээллийг найдвартай архивлан хадгална. |
| 6 | Тухайн онд хүрэх түвшин | УНБМСанд бүртгэгдэх соёлын өвийн бүртгэлийг өмнөхөөс нэмэгдүүлнэ. |
| 7 | Төсөв (шаардагдах нийт зардал) | 288.460.000 төг |

| | | | |
|---|--|--|--|
| | <p align="center">Зардлын гүйцэтгэл</p> | <p>Гүйцэтгэл (өссөн дүнгээр) үүнээс</p> | <p>Нийт: 290.9 сая.төг</p> <p>Улсын төсөв: 290.9 сая.төг</p> <ul style="list-style-type: none"> - 6.5 сая.төг, програм хангамж - 12.0 сая.төг, програм хангамж - 53.2 сая.төг, компьютер, принтер, тог баригч - 138.0 сая.төг. гэрэл зургийн аппарат, фото студи - 38.0 сая.төг, СӨТ-ийн УНБМСангийн архивийн тоног төхөөрөмж - 6.2 сая.төг, СӨТ-ийн интернет, БМСангийн зардал - 8.1 сая.төг, сургалт семинарын зардал - 23.5 сая.төг, 34 байгууллагын интернетийн зардал - 5.4 сая.төг, орон нутагт ажиллах томилолт <p>Гадаадын хандив, тусламж: 0 сая.төг</p> |
| | <p>Тухайн жилд зарцуулсан</p> | | <ul style="list-style-type: none"> - 2006 онд 6,5 сая.төг - 2007 онд 284,4 сая.төг |
| <p align="center">8</p> | <p align="center">Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл</p> | <p>Соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулах програм хангамжийн шаардлага хангасан байдал</p> | <ul style="list-style-type: none"> ▪ Музейнүүдэд тараан суурилуулсан музейн үзмэрийг бүртгэх “RCH буюу Registration of Cultural Heritage” 1.0 програм нь хэвийн ажиллаж музейнүүдээс бүртгэлээ интернет сүлжээгээр УНБМСанд ирүүлж байна. Бүртгэлийн үзмэрийн гэрэл зургийг том хэмжээгээр CD-д буулган баталгаат шуудан болон биечлэн хүргүүлж байгаа юм. Музейнүүдээс ирсэн дээрх үзмэрийн бүртгэлийг УНБМСангийн “Мэдээлэл боловсруулах ССН” програм дээр нэгтгэн цахим хэлбэрээр архивлан хадгалж байна. |
| <p>Мэдээллийн сүлжээнд ашиглагдах компьютер, дагалдах хэрэгсэл, Гэрэл зургийн тоног төхөөрөмжаар хангах</p> | <ul style="list-style-type: none"> ▪ Хөтөлбөрт хамрагдсан музей, эрдэм шинжилгээний хүрээлэн, номын сан, сүм хийд зэрэг 34 байгууллага үзмэр эд өлгийн зүйлээ бүртгэн баримтжуулахад шаардлагатай өндөр хүчин чадал бүхий компьютер, хэвлэх, хувилах үйлдэл бүхий хэвлэгч машин, тог баригч, гэрэл зургийн дижитал аппарат, дуран, гэрэлтүүлгийн хэрэгсэл зэрэг гэрэл зургийн иж бүрэн хэрэгслээр бүрэн хангагдсан. | | |
| <p>Сургалт зохион байгуулах, програмыг эзэмшүүлэх</p> | <ul style="list-style-type: none"> ▪ Соёлын өвийг бүртгэх, бүртгэлийн програм болон тараан суурилуулсан техник хэрэгслийн ашиглах харьцах талаар сургалт семинарыг зохион байгуулан, гарын авлага материалаар хангасан. УНБМСан веб сайт болон байгуулагаас эрхлэн гаргаж байгаа “Соёлын өв” сэтгүүлээрээ дамжуулан соёлын өвийг бүртгэхтэй холбоотой арга зүйн зөвлөмж, мэдээллийг байнга хийж байна. | | |
| <p>Соёлын өвийн УНБМСанд мэдээллээ дамжуулах, бүртгэл мэдээллийг архивлан хадгалах</p> | <ul style="list-style-type: none"> ▪ УНБМСангаас гаргасан графикайн дагуу улс, аймгийн музей нь жилд 32300 үзмэрийн бүртгэлээ ирүүлэхээс ёстойгоос 2009 оны 12 дугаар сарын байдлаар 36 байгууллагын 15052 ширхэг үзмэрийн бүртгэл буюу ирүүлэх ёстой үзмэрийн бүртгэлийн 46.60 %-ийг УНБМСанд хүлээн авсан байна. ▪ 2008 онд Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт орших түүх, | | |

| | | |
|---|---|---|
| | | <p>соёлын үл хөдлөх 317 дурсгал, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх 98 дурсгалыг (нийт 415 нэр төрлийн 4500 гаруй нэгж) бүртгэн тоолсон. Бүртгэгдсэн дурсгалын 20 орчим хувь шинээр улсын бүртгэлд хамрагдаж байгаа юм. Ажлын явцад 16564 ширхэг гэрэл зураг, 83 гар зураг, 396.41 минутын дүрс бичлэгээр баримтжуулсан байна. Бүртгэл тооллогод хамрагдсан дурсгалуудыг багтаасан Хэнтий, Сүхбаатар аймаг тус бүрээр нь цуврал болгон “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал” номыг хэвлүүлэн, улс, аймгийн музей, номын сан, их дээд сургуулиудын номын сан, улсын хэмжээний бүх сумдын соёлын төв зэрэг газруудад үнэ төлбөргүйгээр түгээсэн.</p> <ul style="list-style-type: none"> ▪ 2009 онд Дорнод аймгийн 161 дурсгал, Дорноговь аймгийн 203 дурсгал, Говьсүмбэр аймгийн 17 дурсгал (нийт үл хөдлөх 381 дурсгал)-ыг 14911 ширхэг гэрэл зураг, ойролцоогоор 40 орчим гар зураг, 439.47 минутын дүрс бичлэгээр баримтжуулан бүртгэсэн. Эдгээр 3 аймгийн бүртгэлд хамрагдсан дурсгалуудын “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал” цуврал номыг үргэлжлүүлэн хэвлэхээр бэлтгэж байна. ▪ Утга соёлын өвийн 504 цагийн дүрс бичлэгийн хальс, 280 цагийн аудио дууны хальс, 800 гаруй биет бус соёлын өвийг тээгч холбогдох мэдээллийг улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд шилжүүлэх ажлыг хийж эхлээд байна. УНБМСанд шилжүүлэхдээ эх бичлэгтэй хальсийг mini DV cam, DVD гэсэн 2 хэлбэрээр хуулбарлан, эх бичлэг болон хуулбар гэсэн 2 хэлбэрээр хадгалан архивлах ажлыг хийж байна. ▪ Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоог сайжруулахад “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”-ыг шинэчлэн батлуулсан. |
| 9 | <p>Хөтөлбөрийн үйл ажиллагаа</p> | <ul style="list-style-type: none"> ▪ 2007 оны 10 дугаар сараас эхлэн 2008 оны 12 дугаар сарыг дуустал явагдаж музейн хүн, хүчний ихэнх нь тооллогын ажилд оролцож, соёлын өвийн бүртгэлийн програмын дагуу үзмэрээ бүртгэж, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд үзмэрийн бүртгэлээ ирүүлэх ажил түр хойшлогдсон юм. <p>Улс, аймгийн музейн улсын тооллогын үеэр үзмэрийг гэрэл зургаар баримтжуулан гэрэл зураг авах, музейн ерөнхий бүртгэлийг үйлдэх зэрэг ажилд хөтөлбөрийн хүрээнд музейнүүдэд хүлээлгэн өгсөн гэрэл зургийн студи, компьютер, хэвлэгч техник хэрэгсэл нь хамгийн ихээр хэрэглэгдэж тооллогын ажлыг амжилттай явуулахад чухал үр дүнгээ өгсөн.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Монгол Улсын Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 09-р сарын 27-ны өдрийн 299/324/111 тоот хамтарсан тушаалаар “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл болох булш, |

| | | |
|----|--|---|
| | | <p>хиргисүүр, хадны зураг, бичээс, хөшөө чулуу, сүм хийд, түүний үлдэгдэл, эртний хотын туурь, түүхт овоо суварга зэргийг бүртгэн тоолох ажлыг 2008-2015 онуудад зохион байгуулахаар баталсныг энэхүү хөтөлбөртэй уялдуулан хийж байна.</p> <ul style="list-style-type: none"> Монголын Улсын Засгийн газрын 2008 оны 302-р тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 47-р тушаалын дагуу Соёлын өвийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн “Утга соёлын өвийн үндэсний төв” төрийн бус байгууллагыг Соёлын өвийн төвд нэгтгэхийг заасан нь утга соёлын өвийн бүртгэн баримтжуулагдсан хэрэглэгдэхүүнийг улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүртгэх, биет бус соёлын өвийн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх боломжтой болсон. |
| 10 | Дүгнэлт | <p>“Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр” нь соёлын өвийг бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоог сайжруулахад зохих үр дүнгээ өгч байна.</p> <p>Уг хөтөлбөр нь соёлын өвийн бүртгэлийн програм зохион нэгдсэн сүлжээ бий болгох, соёлын өвийг бүртгэн баримтжуулахад техник хэрэгслээр хангах, боловсон хүчинг бэлтгэх, сургалт зохион байгуулах зэрэг зорилтуудыг биелүүлсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> Байгууллагуудыг үзмэр бүртгэн баримтжуулах ажилд шаардагдах техник хэрэгслээр бүрэн жигд хангасан. Өндөр хүчин чадал бүхий компьютер, гэрэл зургийн студиэр хангаж, бүртгэлийн програмтай болсноор соёлын өвийн бүртгэн баримтжуулалтын ажилд техник технологийн шинэ дэвшил гарсан. Хөтөлбөрт хамрагдсан байгууллагуудыг интернет сүлжээнд холбосноор бүртгэл, мэдээллийг түргэн шуурхай дамжуулах бололцоотой болсон. Музейнүүд үзмэрээ бүртгэх, байгууллагын бүртгэл-мэдээллийн сангаа бүрдүүлэхэд ахиц гарч байгаа ч зохих үр дүндээ хүрэхгүй байна. Музейн ажилтнуудын үзмэрийн бүртгэл, тодорхойлолт бичих талаар бүрэн дадлагажиж төлөвшөөгүй, үзмэрийн гэрэл зургаа авах талаар мэргэшээгүй, мэргэжлийн гэрэл зурагчин байхгүй байна. Музей бүр үзмэрээ бүртгэн баримтжуулах үйл ажиллагаагаа эрчимжүүлэх шаардлагатай байна. |
| 11 | Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал | <ul style="list-style-type: none"> 2007-2008 онд улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллого явагдсан холбоотой музейн үзмэрээ бүртгэх, УНБМСанд үзмэрийн бүртгэл ирүүлэх ажил түр хойшлогдсон. Хөтөлбөрт хамрагдсан музей, байгууллагууд үзмэрээ бүртгэн баримтжуулах, соёлын өвийн УНБМСанд бүртгэл мэдээллээ ирүүлэх талаар идэвхгүй байгаа. Хөдөө орон нутагт зарим музейн жилийн төсвөөс интернетийн зардлыг хассан. |
| 12 | | <ul style="list-style-type: none"> Соёлын өвийг хадгалж байгаа байгууллагууд үзмэр, |

| | | |
|----|---|---|
| | Эдгээрээс гарах арга зам | <p>эд өлгийн зүйлээ бүртгэх үйл ажиллагаагаа идэвхжүүлэх.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Хөтөлбөрт хамрагдсан байгууллагуудын удирдлага үзмэрээ бүртгэн баримтжуулалтын ажилд хөдөлмөрийн хуваарь, мэргэжилтний зарцуулах цагийг түлхүү тавьж өгөх, тэднийг мэргэшүүлэн сургах, тогтвор сууршилтай ажиллахад анхаарч, дэмжлэг туслалцаа үзүүлэх. ▪ Байгууллагын төсөвт интернетийн зардлыг хасалгүйгээр, жил бүр тусгаж байх. |
| 13 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ | <ul style="list-style-type: none"> ▪ Соёлын өвийн төв нь музейг үзмэрээ бүртгэн баримтжуулж бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэхэд, мэргэжил арга зүйгээр хангаж, туслалцаа дэмжлэг үзүүлэн, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахын төлөө бүхий л бололцоогоор чармайн ажиллаж байна. ▪ Хөтөлбөрт хамрагдаж байгаа музей, эрдэм шинжилгээний байгууллага, сүм хийд үзмэр, эд өлгийн зүйлээ бүртгэх, бүртгэл-мэдээллийн сангаа бүрдүүлэх, Соёлын өвийн УНБМСанд бүртгэлээ цаг тухайд нь хүргүүлэх ажлаа идэвхжүүлэх нь чухал байна. Дан ганц Соёлын өвийн төвийн идэвх зүтгэлээр энэ хөтөлбөр үр дүнд хүрэхгүй. |
| 14 | Хөтөлбөрийн талаархи яамны санал | <ul style="list-style-type: none"> ▪ Музейн үзмэр, түүх соёлын дурсгалт зүйлийг бүртгэн баримтжуулах ажил нь цаг хугацаа их зарцуулагдах учир хөтөлбөрийг үр дүнд хүргэхэд цаашид үргэлжлүүлэх. ▪ Музейн үзмэрээ бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг нь идэвхжүүлэх бодлого баримтлах. ▪ Хөтөлбөрт хамрагдсан байгууллагуудад тараан суурилуулсан техник технологийн шинэчлэлтийг цаг тухайд нь хийхэд дэмжлэг үзүүлэх. |
| 15 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын оролцооны талаархи санал | <ul style="list-style-type: none"> ▪ Аймгийн Засаг дарга нар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахад музейн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж: <ul style="list-style-type: none"> - Интернетийн зардлыг жил бүр музейн төсөвт суулгаж өгөх - Музейг үзмэрээ бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сангаа бүрдүүлэхэд шаардагдах материал хэрэгслээр хангахад санхүүжилтийг нэмэгдүүлэх, ажиллах хүчин, байрны нөхцлийг сайжруулах - Орон нутгийнхаа хэмжээнд түүх, соёлын үл хөдлөх дурсгал, утга соёлын өвийг бүртгэн баримтжуулах, мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулан ажиллах шаардлагатай байна. |

Соёлын өвийн төв